

## МОНГОЛ УЛСЫН АГААРЫН ТЭЭВРИЙН САЛБАРТ КОВИД-19-ИЙН НӨЛӨӨ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

Л.Наранчимэг\*, Д.Дэлгүүнгэрэл\*\*

**Хураангуй:** Ковид-19 цар тахлын улмаас дэлхийн улс орнууд 2020 онд урьд өмнө нь тулгарч байгаагүй гэнэтийн гүн хямралтай нүүр тулж, дэлхийн эдийн засаг 3,2 хувиар агшив. Аялал жуучлал, худалдаа үйлчилгээ, тээвэр зэрэг эдийн засгийн салбаруудын үйл ажиллагаа богино хугацаанд хумигдаж, цар тахлын цохилтод өртсөн. Дэлхий даяар 2020 оны байдлаар ойролцоогоор 141 сая ажлын байрны хомсдол бий болсноос 88 сая хүн эдийн засгийн идэвхгүй ангилалд, 33 сая хүн ажилгүй ангилалд шилжжээ. Ковид-19 цар тахал нь эдийн засгийн салбаруудад тэр дундаа агаарын тээврийн салбарт ихээр нөлөөлж, сөрөг үр дагаврыг бий болгосон. Манай улсын агаарын тээврийн салбарт Ковид-19-ийн нөлөөллөөр эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд өмнөх 3 жилийн дунджаас 21-42 хувиар буурчээ.

**Түлхүүр үгс:** Ковид-19 цар тахлын нөлөө агаарын тээврийн салбарт, тээвэрлэсэн ачаа, зорчигчийн тоо, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь

### Impacts and challenges of Covid 19 in Mongolian Airline Industry

**Abstract:** In 2020 due to unprecedented Covid-19 pandemic, the world faced 3.2 percent economy crisis. Tourism, trade and transportation sectors were hit hard by pandemic in a short period of time. As of 2020, there were approximately 141 million job shortages worldwide, of which 88 million were classified as economically inactive and 33 million as unemployed. The COVID-19 epidemic has had a devastating effect on economic sectors, including the airline industry. As a result of the Covid-19 pandemic, the economy in Mongolian Airline industry decreased by 21-42 percent from the average of the previous 3 years.

**Keywords:** The impact of the Covid-19 pandemic on the airline industry, the number of cargo and passengers and a percentage of GDP

\* МУИС-ийн Бизнесийн сургууль, (E-mail): naranchimeg\_l@num.edu.mn

\*\* МУИС-ийн Бизнесийн Сургууль, (E-mail): Delguungerel@gmail.com

### Ковид-19-ийн нөлөө дэлхийн агаарын тээврийн салбарт


Олон улсын агаарын тээврийн холбоо /IATA/-с зорчигчийн тоог Ковид-19-ийн өмнөх үе буюу 2019 оны эхний 10 сартай харьцуулахад орон нутгийн зорчигчийн тоо 21.6 хувиар, олон улсын зорчигчийн тоо 65.5 хувиар нийтдээ дэлхий даяар 49.4 хувиар буурсан байна. 2020 оны мөн үетэй харьцуулахад олон улсын зорчигчийн тоо 177.8 хувиар, орон нутгийн зорчигчийн тоо 33.2 хувиар нийтдээ 71.9 хувиар өссөн нь дэлхийн агаарын тээвэр аажмаар сэргэж эхэлж байгааг илтгэж байна.<sup>3</sup>

Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/-с зорчигчийн орлогыг 2019 онтой харьцуулахад зорчигчийн орлого ойролцоогоор 324-325 сая ам.доллаароор тус тус буурсан тухай мэдээлсэн байна.<sup>4</sup>

Ковид-19 цар тахлын урт хугацааны хямралтай холбоотой дэлхий даяар агаарын тээврийн компаниудад улс орнуудын засгийн газрууд дэмжлэг үзүүлсээр байна. Засгийн газрын дэмжлэг нь хөрөнгө оруулах, зээл олгох, төлбөр хойшлуулах, татварын өрийг багасгах гэх мэт олон төрөл байна.

2021 оны 09 сарын байдлаар зарим улсын засгийн газрууд ажлын байрыг хадгалахад зориулалтаар цалинд 81 тэрбум ам.доллар, 73 тэрбум ам.долларын зээл, зээлийн баталгаанд 26 тэрбум ам.доллар, онгоцны билетийн татвар, аж ахуй нэгжүүдийн татварууд, шатахууны татвар гэх мэтээр нийт 243 тэрбум ам.долларын буцалтгүй болон дараа төлөх нөхцөлтэйгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.

График 1. Ковид-19-тэй холбоотой Засгийн газрын тусламж-Бүс нутгаар /тэрбум ам.доллар/



Эх сурвалж: IATA. (2021). Annual review 2021

<sup>3</sup> International air transport association. (2021). Air passenger market analysis. Retrieved December 02, 2021, from <https://www.iata.org/en/iata-repository/publications/economic-reports/air-passenger-monthly-analysis--october-2021/>

<sup>4</sup> International Civil Aviation Organization. (2021). Estimated results in brief. Effect of Novel Coronavirus (COVID-19) on Civil Aviation, 1-6.

График 1-с харахад Ковид-19 цар тахалтай холбоотой засгийн газрын тусламж Хойд Америкт буюу 104 тэрбум ам.доллар дэмжлэг авсан байна.

Ковид-19-ийн үеэр засгийн газрын дэмжлэг, тусламж авч чадаагүй мөн санхүүгийн хүндрэлийн улмаас Ази, номхон далайн бүсийн Air Asia Japan, Cathay Dragon, Nok Scoot, Bek Air гэх 4 компани, Хойд Америк, Карибын тэнгисийн орнуудаас Nantucket Express, Trans States Airlines, Compass Airlines, Air Georgian, Shoreline Aviation, Jet Lines, Paradigm Air, Pen Air, Island Express 9 компани, Европ тивээс Germanwings, Level Paris, Atlas Global, Air Italy, Ernest Airlines, Cargo Logic Air, Atlantis, Montenegro Airlines 8 компани, Ойрх Дорнодын улсаас Wings of Lebanon 1 компани, Латин Америкаас Avianca Peru, LATAM Argentina, One Airlines, Flyest, Tame ER, Austral 6 компани, Африк тивээс South African Airways, South African Express, Comair, Kulula, Air Mauritius 5 компани нийтдээ 33 агаарын тээврийн компани санхүүгийн хямралд өртөж дампуурлаа зарласан байна.<sup>5</sup>

2021 оны төгсгөл гэхэд урьдчилсан тооцоогоор шатахууны төлбөр 100 тэрбум ам.долларт хүрч 2020 онтой харьцуулахад 28.2 хувиар өсөхөөр байна. Энэ нь үйл ажиллагааны зардлын 19 хувийг эзэлж байна. Шатахууны баррелийн үнэ 74.5 ам.доллар болж 2020 онтой харьцуулахад 27.9 ам.доллар буюу 59.9 хувиар өссөн байна.<sup>6</sup>

Ковид-19 цар тахал нь Дэлхийн 2-р дайн, 2001.09.11-ний террорист халдлага, 2007-2008 оны Дэлхийн санхүүгийн хямралаас ч илүүтэй агаарын тээврийн салбарын үйл ажиллагаанд хүчтэй нөлөөлж байна. Мөн 2020 оны 2-р хагаст агаарын тээврийн салбарын татварын дараах цэвэр алдагдал 118 тэрбум ам.доллар болон түүнээс дээш давах магадлалтай гэж тооцож байсан.<sup>7</sup>

2020 онд агаарын тээврийн салбар 137.7 тэрбум ам.долларын алдагдалтай ажилласан байна.<sup>8</sup>

Олон улсын агаарын тээврийн холбоо /IATA/-ны ерөнхий захирал Willie Walsh 2021 оны 10 дугаар сарын 4-ний өдөр агаарын тээврийн компаниудын хувьд Ковид-19-ийн нөлөө асар их байна. Агаарын тээврийн компаниуд оршин тогтнохын тулд зардлаа эрс бууруулах замаар бизнесээ авч үлдэх гэж хичээн ажиллаж байна.

Ингэснээр дэлхийн агаарын тээврийн салбар 2021 онд 51.8 тэрбум ам.долларын алдагдалтай ажилласан байна. 2021 оны хувьд дэлхийн агаарын

<sup>5</sup> International air transport association. (2021). Relief measures in 2021. Annual review 2021, 22-23.


<sup>6</sup> International air transport association. (2021). Economic performance of the airline industry. 3-4.

<sup>7</sup> International air transport association. (2020). The industry story in 2020. Annual review 2020, 11-16.

<sup>8</sup> International air transport association. (2021). Assessing COVID-19's economic toll. Annual review 2021, 10-17.

тээврийн салбарын алдагдлын дийлэнх хувийг Ази номхон далайн болон европ тивүүд хүлээж байна.

График 2. Дэлхийн агаарын тээврийн салбарын алдагдал-Бүс нутгаар (2021он)



Эх сурвалж: IATA. (2021). Annual review 2021

Мөн энэхүү алдагдал нь 2022 онд 11.6 тэрбум ам.доллар болж буурах төлөвтэй байгааг мэдээлсэн байна. Ковид-19 цар тахлын нөлөөгөөр 2020-2022 оны хооронд дэлхийн агаарын тээврийн салбарын алдагдал 201 тэрбум ам.доллар болон түүнээс дээш давах магадлалтай байна хэмээн мэдээлсэн байна.<sup>9</sup>

### Ковид-19-ийн нөлөө Монгол Улсын агаарын тээврийн салбарт

2021 оны эхний 9 сарын байдлаар Монгол Улсын нийт тээврийн салбарын орлого 1,341.5 тэрбум төгрөг буюу Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 4.5%-ийг эзэлж байна. Үүнээс агаарын тээврийн салбарын орлого ДНБ-ний хувьд 2019 онд 1.3%, 2020 онд 0.4%, 2021 оны эхний 9 сарын байдлаар 0.4%-ийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 1. Дотоодын нийт бүтээгдэхүүнд тээврийн салбарын эзлэх хувь хэмжээ

№	Салбар	Тээврийн салбарын нийт орлого салбар бүрээр (тэрбум төг)					
		2019		2020		2021.10 сар хүртэл	
	ДНБ (тэрбум төг)		Хувь		Хувь		Хувь
1	Төмөр замын	708.6	1.9	770.1	2.1	594.5	2.0
2	Авто зам	796.1	2.1	564.4	1.5	618.8	2.1

<sup>9</sup> International air transport association. (2021). Annual general meeting 2021. Retrieved October 04, 2021, from <https://www.iata.org/en/pressroom/2021-releases/2021-10-04-01/>

3	Агаарын тээвэр	498.7	1.3	164.1	0.4	128.2	0.4
4	Усан замын	0.2	0.0	-	0.0	-	0.0
Нийт дүн		2,003.5	5.3	1,498.6	4.0	1,341.5	4.5

Эх сурвалж: www.1212.mn

Манай улсын агаарын тээврийн салбарт Ковид-19-ийн нөлөөлөөр эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд өмнөх 3 жилийн дунджаас 21.42 хувиар буурчээ.

### Хүснэгт 2. Үндэсний тээвэрлэгчийн үндсэн үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	2018	2019	2020	Өмнөх 3 жилийн дундаж	2021.10 сар хүртэл	Өөрчлөлт	
						Мян.төг	Хувиар
1.Үндэсний тээвэрлэгчийн тээсэн ачаа (тн)	5,752.0	5,761.0	2,740.6	4,751.2	3,316.9	576.3	21
2.Тээврийн орлого (тэрбум төг)	442.3	498.7	164.1	368.4	128.2	-35.9	-22
3.Олон улсын нислэгийн тоо	8,505.0	10,142.0	1,721.0	6,789.3	1,380.0	-341.0	-20
4.Орон нутгийн нислэгийн тоо	6,394.0	7,967.0	5,563.0	6,641.3	3,205.0	-2,358.0	-42
5.Зорчигчийн орлого (тэрбум төг)	420.2	473.7	155.9	349.9	121.8	-34.1	-22

Эх сурвалж: www.1212.mn


2021 оны эхний 9 сарын байдлаар Монгол Улсын агаарын тээврийн салбарын хувьд олон улсад 3,281.47 тонн ачаа, орон нутагт 35.47 тонн ачаа нийтдээ 3,316.9 тонн ачаа тээвэрлэсэн байна.

Нийт тээвэрлэсэн ачааны 98.9%-ийг олон улсын ачаа тээвэрлэлт, 1.1 хувийг орон нутгийн ачаа тээвэрлэлт эзэлж байна.

2021 оны эхний 9 сарын байдлаар тээврийн орлого 128.2 тэрбум төгрөг, зорчигчийн орлого 121.8 тэрбум төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 22 хувиар буурчээ.

2021 оны 1-10-р саруудын үзүүлэлтүүдийг 2020 оны мөн үетэй зэрэгцүүлж үзлээ.


График 3. Агаарын тээврийн салбарын тээвэрлэсэн ачаа (2021/2020 оны харьцуулалт)



Эх сурвалж: [www.1212.mn](http://www.1212.mn)

Агаарын тээвэрээр тээвэрлэсэн ачаа, шуудангийн үзүүлэлт 2020 оны мөн үетэй харьцуулахад нийт дүнгээрээ 1,706 тонн буюу 78%-иар өссөн байна.

График 4. Агаарын тээврийн салбарын тээвэрлэсэн зорчигчийн тоо (2021/2020 оны харьцуулалт)




Эх сурвалж: [www.1212.mn](http://www.1212.mn)

Агаарын тээврийн салбар гол үзүүлэлт болох тээвэрлэсэн зорчигчийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад олон улсын зорчигчийн тоо 59%-иар, орон нутгийн зорчигчийн тоо 73%-иар буюу нийтдээ 290,130 зорчигчоор буюу 68%-иар буурсан байна.

Олон улсын нислэгийн тоог 2020 оны мөн үетэй харьцуулахад 199 нислэгээр буюу 13%-иар буурсан байна. Харин орон нутгийн нислэгийн 2020 онтой харьцуулахад 1,424 нислэг буюу 27%-иар буурсан байна.

График 5. Агаарын тээврийн салбарын орлого (2021/2020 оны харьцуулалт)



Эх сурвалж: www.1212.mn

2021 оны эхний 10 сарын байдлаар агаарын тээврийн салбарын орлого 147.7 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12%-иар өссөн үзүүлэлттэй байна. 2019 оны мөн үетэй харьцуулахад 294.3 тэрбум төгрөг буюу 66.5%-иар буурсан байна.

График 6. Олон улсын зорчигч тээвэрлэлт (2021/2020 оны харьцуулалт, зорчигчдын тоогоор)

Агаарын тээвэрлэгч	2019 оны эхний 10 сар	2020 оны эхний 10 сар	2021 оны эхний 10 сар	2020 оны мөн үетэй харьцуулахад		2019 оны мөн үетэй харьцуулахад	
				Тоогоор	Хувиар	Тоогоор	Хувиар
МИАТ ХК	517,517	84,675	31,045	(53,630)	-63	(486,472)	-94
Хүннү Эйр	63,803	3,706	4,366	660	18	(59,437)	-93
Аэро Монголиа	21,179	2,214	2,906	692	31	(18,273)	-86
Изинис Эйрвэйз	12,060	2,811	-	(2,811)	-100	(12,060)	-100
Корсан Эйр	144,408	19,844	7,487	(12,357)	-62	(136,921)	-95
Туркиш Эйрлайнс	34,709	12,669	13,979	1,310	10	(20,730)	-60
Ашиана Эйрлайнс	23,792	10,293	4,025	(6,268)	-61	(19,767)	-83
Эйр Бусан	36,258	3,426	131	(3,295)	-96	(36,127)	-100
Эйр Чайна	87,889	6,679	-	(6,679)	-100	(87,889)	-100
Аэрофлот	65,657	6,499	-	(6,499)	-100	(65,657)	-100
Ангара Эйрлайнс	3,080	-	-	-	-	(3,080)	-100
СКАТ	7,343	2,754	-	(2,754)	-100	(7,343)	-100
Чартер	8,636	2,422	1,606	(816)	-34	(7,030)	-81
<b>НИЙТ</b>	<b>1,026,331</b>	<b>157,992</b>	<b>65,545</b>	<b>(92,447)</b>	<b>-59</b>	<b>(960,786)</b>	<b>-94</b>

Эх сурвалж: Иргэний нисэхийн тээвэрлэлтийн мэдээ-2021.10 сар

2021 оны эхний 10 сарын байдлаар олон улсын чиглэлд 12 агаарын тээвэрлэгч компани нийт 65,545 зорчигч тээвэрлэсэн бөгөөд 2019 оны мөн

үетэй харьцуулахад 94%-иар, 2020 оны мөн үетэй харьцуулахад 59%-иар тус тус буурсан байна.

2021 оны олон улсын нислэгийн зорчигчийн 47%-ийг үндэсний агаарын тээвэрлэгч МИАТ ХК, 7%-ийг Хүннү эйр ХХК, 4%-ийг Аэромонголиа ХХК тус тус тээвэрлэсэн бол гадаад тээвэрлэгчид 42% буюу 27,529 зорчигч тээвэрлэсэн байна.

### **Монгол Улсын агаарын тээврийн салбарт тулгамдаж буй асуудлууд**

1. Ковид-19 цар тахлын үед үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах үүднээс агаарын тээврийн компаниуд 2020.01 сараас 2021.05 сар хүртэл ажиллагсдадаа үндсэн цалингийн 50-60% -иар цалинжуулсан байна. Мөн цар тахлын үед төрийн явуулж буй бодлого, шийдвэр байнга өөрчлөгдөж байгаагаас үүдэн үйл ажиллагаанд доголдол үүсч эхэлсэн байна.
2. Шинэ нисэх онгоцны буудал ашиглалтад орсонтой холбогдуулан 2021.07.04-ны өдрөөс эхлэн төрийн болон хувийн хэвшлийн агаарын тээврийн компаниудын үйл ажиллагааг нүүлгэн шилжүүлсэн. Өнөөдрийн байдлаар шинэ нисэх онгоцны буудлын газрын үйлчилгээний төлбөр, хураамж хэт өндөр байгаа нь төрийн болон хувийн хэвшлийн компаниудад санхүүгийн хувьд сөргөөр нөлөөлж байна.
3. Төрөөс иргэний нисэхийн салбарт баримтлах бодлогын хүрээнд агаарын хөлгийн шатахууныг олон эх үүсвэрээс бүрдүүлэх, монополийг задалж чөлөөт өрсөлдөөнийг дэмжих үүднээс агаарын хөлгийн шатахууны үнийг дэлхийн зах зээлийн ханш, үнэлгээнд нийцүүлэх талаарх судалгааг жил бүр хийдэг ч дорвитой арга хэмжээнд хүрч чадахгүй байна.

Монгол Улсын хувьд зөвхөн ОХУ-аас агаарын хөлгийн ТС-1 төрлийн шатахууныг импортолдог бөгөөд өнөөдрийн байдлаар ОХУ-с нийлүүлдэг шатахууны хэмжээ багассан нь шатахууны хомсдолд орох нөхцөл байдлыг үүсгээд байна. Шатахууны нөөц хангалтгүй байгаагаас үүдэн алслагдсан аймгууд болон баруун аймгууд руу орон нутгийн нислэг үйлдэх боломжгүй байдалд хүрэхэд ойрхон байна.

### **Санал**

1. Түлш нийлүүлэх байгууллагыг бодлогоор дэмжиж, шударга өрсөлдөөнийг бий болгож монополь байдлаас гаргах хэрэгтэй байна. Баруун бүсийн аймгуудын түлшний нийлүүлэлтийг хямд, ойроос нийлүүлэхийг бодлогоор дэмжих хэрэгтэй.



2. Баруун, зүүн бүсийн хилийн боомтоор агаарын хөлгийн шатахуун оруулж, шатахууны импортын гаалийн татварыг бууруулах хэрэгтэй байна.
3. Төрөөс агаарын тээврийн салбарын аж ахуйн нэгж нэгжүүдийн төрөл бүрийн татвар, өрийг танаж тэдгээрт санхүүгийн дэмжлэг үзүүлэх
4. Тайванийн тээвэр, харилцаа холбооны яам болон жижиг дунд бизнесийн зээлийн батлан даалтын сан хамтран нисэхийн салбарт санхүүгийн дэмжлэг үзүүлэх зээлийг бий болгосон туршлагыг манайд ч нэвтрүүлэх боломжтой юм.
5. Иргэд, аж ахуйн нэгжүүдийн хувьд нислэгийн тийзний зээлийн бүтээгдэхүүнийг бий болгох, хөгжүүлэх
6. Агаарын тээвэр, аялал жуулчлалын салбар хоорондын хөгжлийн уялдаа холбоо, хамтын хүчин чармайлтыг дэмжих зохицуулалт хийх
7. Аялал жуулчлалын захиалгат нислэгийн зохицуулалтыг өргөжүүлэх
8. Орон нутгийн тийзний үнийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх
9. Засгийн газрын зүгээс агаарын тээврийн салбарыг сэргээхийн өр төлбөрийн тодорхой хэсгийг хөнгөлөлт чөлөөлөлтөд хамруулах шаардлагатай байна.

### **Ашигласан материал**

Иргэний нисэхийн тээвэрлэлтийн мэдээ-2021.10 сар

International Civil Aviation Organization. (2021). Estimated results in brief. Effect of Novel Coronavirus (COVID-19) on Civil Aviation, 1-6.

International air transport association. (2021). Relief measures in 2021. Annual review 2021, 22-23.

International air transport association. (2021). Economic performance of the airline industry. 3-4.

International air transport association. (2020). The industry story in 2020 I. Annual review 2020, 11-16.

International air transport association. (2021). Assessing COVID-19's economic toll. Annual review 2021, 10-17.

[www.1212.mn](http://www.1212.mn)

[www.mcaa.gov.mn](http://www.mcaa.gov.mn)

- International air transport association. (2021). Annual general meeting 2021. Retrieved October 04, 2021, from <https://www.iata.org/en/pressroom/2021-releases/2021-10-04-01/>
- International air transport association. (2021). Air passenger market analysis. Retrieved December 02, 2021, from <https://www.iata.org/en/iata-repository/publications/economic-reports/air-passenger-monthly-analysis---october-2021/>